



ХӨВСГӨЛ АЙМАГ  
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 03

Булгантал

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлого,  
зардлыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "б", Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 3 дугаар 3.5.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх санд 2021 онд 35000.0 сая төгрөгийг зээлийн санд татан төвлөрүүлж, 50000.0 сая төгрөгийг журмын дагуу төсөл сонгон шалгаруулж зарцуулахыг сумын Засаг дарга (П.Ариунбат)-д зөвшөөрсүгэй.

2. Сум хөгжүүлэх сангийн 2021 онд төвлөрүүлэх зээлийн хүүгийн орлогыг 4650.0 мянган төгрөгөөр баталсугай.

3. 2021 оны зээлийн хүүгийн орлогоос орох хүүгийн 50 хувь болох 2325.0 мян.төгрөгийг зээлийн санд, үлдэгдэл 2325.0 мянган төгрөгийг доорх үйл ажиллагаанд зарцуулахыг сумын Засаг дарга /П.Ариунбат /-д зөвшөөрсүгэй.

Үүнд:

А. Зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмлэг үзүүлэх сургалтанд – 1395.0 мян.төгрөг

Б. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд – 930.0 мян.төгрөг

4. Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогоос орсон орлогыг батлагдсан зардлаар санхүүжүүлэхийг сумын Санхүүгийн албаны дарга (Б.Нямбаяр)-д зөвшөөрсүгэй.

5. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Б.Эрдэнэ-Оюун)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.АНХБАЯР

